



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 05 сарын 24 өдөр

Дугаар А/160

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны “Зөвлөлийн бүрэлдэхүүн, журам шинэчлэн батлах тухай” А/163 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Нислэгийн цагийн хуваарийг зохицуулах журам”-ын 5.1 “Олон улсын болон орон нутгийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийн хүсэлтийг улирал эхлэхээс 30 хоногийн өмнө Зөвлөлийн нарийн бичгийн даргад Хавсралт 1-ийн дагуу цахимаар ирүүлнэ” гэснийг “Олон улсын болон орон нутгийн хуваарьт нислэгийн цагийн хуваарийн хүсэлтийг улирал эхлэхээс 60-аас доошгүй хоногийн өмнө Зөвлөлийн нарийн бичгийн даргад Хавсралт 1-ийн дагуу цахимаар ирүүлнэ” гэж өөрчилсүгэй.

2.Журмыг мөрдөж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын навигаци, нисэх буудлын бодлого зохицуулалтын газар (Ч.Одгэрэл)-т үүрэг болгосугай.

3.Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2022 оны “Зөвлөлийн бүрэлдэхүүн, журам шинэчлэн батлах тухай” А/163 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтад өөрчлөлт орсонд тооцугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА